





**БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ,  
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДОТООД ДҮРЭМ**

Хувилбарын дугаар:1  
Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-10-25  
Баримт бичгийн дугаар:01

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, нэгжүүд		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан.	Ц.Лувсандамдин Б.Эрдэнэзул	ЭМТҮЧАБ Албаны дарга Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны эрсдэлийн менежер	
Санал өгсөн	Д.Баянмөнх	Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
Хянаж баталсан	Г.Дашжанцан	БОЭТөвийн захирал	

**Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл**

<b>Хувилбарын дугаар</b>	<b>Хүчин төгөлдөр болсон огноо</b>	<b>Өөрчлөлтийг батласан албан тушаалтан</b>	<b>Өөрчлөлтийн утга</b> (баримт бичигт ямар өөрчлөлт орсоныг товч тайлбарлана)
1			
2			
3			
4			
5			
6			

ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ,  
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДОТООД ДҮРЭМ

**Нэг. Зорилго**

Эрүүл мэндийн салбарт эмчилгээ, оношилгоонд ашиглаж буй ионжуулагч цацрагийн үүсгүүрийн үйлчлэлээс хүний эрүүл мэндийг хамгаалах, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, цацрагийн аюулгүй байдлыг хангуулах, цацрагийн үүсгүүрийг зөвшөөрөлгүй этгээд ашиглах, зөвшөөрөлгүй шилжүүлэх, үрэгдүүлэх, гэмтээх болон олж авснаас хүрээлэн буй орчин, нийгэм болон хувь хүнд учирч болох цацрагийн осол аюулаас урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй байдлыг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5 дахь заалтын хэрэгжилтийг хангах, цацрагийн үүсгүүр хэрэглэгч байгууллагын дотоодын хяналтыг чангатгахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

**Хоёр. Ерөнхий зүйл**

1. Цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага нь үйл ажиллагааны онцлог, цацрагийн үүсгүүрийн тоо, аюулын зэрэглэл, цацрагтай ажиллагчдын тоо зэргийг харгалзан дотоодын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий цацрагийн хяналтын ажилтанг захирлын тушаалаар томилон ажиллуулна.
2. Энэхүү дүрмийг үндэслэн байгууллага өөрийн цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын ажлын хэсгийн мөрдөх дүрмийг ашиглаж буй цацрагийн үүсгүүр, цацрагтай холбогдолтой үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж батлуулна.
3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын ажлын хэсгийн гол зорилго нь хүрээлэн буй орчны хамгаалалт, цацрагтай ажиллагчдын шарлагын тунг хянах, цацрагийн аюулгүйн норм ба шаардлага, цацрагийн аюулгүй ажиллагааны дүрмийн биелэлтэд хяналт тавьж, цацрагийн аюулгүй байдлыг хангуулах, зайлшгүй шаардлагатай мэдээллээр байгууллагын удирдлагыг хангахад оршино.
4. Байгууллагын цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын дотоод дүрэм, аюулгүйн шаардлагуудыг явуулж буй үйл ажиллагааны онцлог, цацрагтай холбогдсон ажлын хэмжээ, төрөл, шинж чанар, ашиглаж буй цацрагийн үүсгүүрийн аюулын зэрэглэл зэргийг тооцсоны үндсэн дээр цацрагийн хяналтын улсын байцаагчаар хянуулж, байгууллагын захирал батална.
5. Ионжуулагч цацрагийн үүсгүүр бүхий аппарат тоног төхөөрөмжийг ашиглан оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулах байрны цацрагийн хамгаалалт аюулгүйн шаардлага хангагдсан тухай БШУЯамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хяналтын хэлтсээр (ББАБХХ) үнэлгээ гаргуулан цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл авсан байх ба зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө ЦЦАБХХ-д хандан цацрагийн аюулгүйн дүгнэлт гаргуулж эрхээ сунгуулна.
6. Цацрагийн үүсгүүр бүхий рентген аппаратыг хүлээж авснаас хойш ажлын 3 хоногийн дотор ЦЦАБХХ-д мэдэгдэж бүртгүүлнэ.

## Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дотоод дүрэм 2023 он

7. Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа Цөмийн энергийн тухай хууль, ионжуулагч туяа үүсгэгч аппарат дээр ажиллахад дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын заалтуудыг дагаж мөрдөнө.
8. Цацрагийн үүсгүүр бүхий аппаратыг шинээр буюу шилжүүлэн суурилуулах, худалдах, ашиглалтаас гаргах, рентген хоолойг солих бүрт ЦЦАБХХ-д мэдэгдэнэ.
9. Цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийг суурилуулсан өдрөөс эхлэн аппарат тоног төхөөрөмжийн ашиглалтын бүртгэл хөтөлж тайлан мэдээ судалгааг жил бүрийн эцэст ЦЦАБХХ-д мэдээлнэ.
10. Цацрагийн үүсгүүрээр оношилгоо, эмчилгээ хийхдээ ашиглаж буй тоног төхөөрөмжийн чанарын баталгаажилтыг тогтмол хийлгэж байна.
11. Рентген аппаратыг ажиллуулах, угсрах, засах ажилд 18 аас дээш насны рентген техникч, лаборантын болон засварчны мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, цацрагийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалтанд хамрагдсан хүнийг ажиллуулна.

### Гурав. Рентгений өрөөг зохион байгуулахад тавигдах шаардлага

1. Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа ажлын байрын цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага хангагдсан тухай ЦЦАБХХ-р үнэлгээ гаргуулсан зориулалтын байранд явуулна.
2. Рентген оношилгооны өрөөг зөвхөн рентген оношилгооны чиглэлээр ашиглах ба өрөөний талбайн хэмжээ хангалттай, цацрагийн хамгаалалт дүрмийн дагуу баригдсан эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (өрөөний хана, хаалга, шал, таазны хамгаалалтыг цацрагийн аюулгүйн стандартын дагуу хийх)
3. Рентген оношилгооны өрөө нь хуурай байх ба агаарын харьцангуй чийглэг бүх өрөөнд 40-60% байна.
4. Өрөө нь агааржуулалтын системтэй, агааржуулалтыг тогтмол хийдэг байна. (1 цагт 2-3 удаа агаар солилцоо хийх)
5. Рентген оношилгооны өрөө, удирдах самбарын өрөөнүүд тусдаа, хамгаалалт бүхий цонх хаалгаар тусгаарлагдсан байна.
6. Рентген оношилгооны өрөөнд хувийн хамгаалалтын хэрэгслүүд байх ба тэдгээрийн тугалган эквивалентийг үзүүлсэн тамга тэмдэгтэй байна. Хамгаалалтын хэрэгслийн чанарыг жилд 1 удаа шалгах ба нугарч урагдахаас хамгаалан зөв хадгалах шаардлагатай. (өлгүүрт өлгөж хадгална)
7. Рентген оношилгооны өрөөний үүдэнд рентген оношилгоо хийж байх үед асах гэрлэн дохиолол болон цацрагийн аюулгүйн тэмдэг, санамжийг иргэдэд ойлгомжтойгоор бичиж байрлуулна.

### Дөрөв. Цацрагийн хамгаалалтын үндсэн зарчим

1. Рентген шинжилгээг зөвхөн эмчийн заалтаар хийнэ.
2. Үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхийг хориглоно.
3. Шарлагын тунг зохистой хэмжээний доод түвшинд байлгана.
4. Хүн ам түүний дотор цацрагтай ажиллагчийг шарлагын тунгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхийг хориглоно.
5. 18 нас хүрээгүй үйлчлүүлэгчийн рентген шинжилгээг хийхийн өмнө асран хамгаалагчаас зөвшөөрөл авч гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.
6. Нөхөн үржихүйн насны эмэгтэйдгээс нуруу, аарцгийн хөндийн рентген шинжилгээ хийхийн өмнө сүүлийн сарын тэмдэг хэзээ ирсэн, жирэмсэн эсэхийг заавал асууж тодруулна.

**Тав. Байгууллагын удирдлагад тавигдах шаардлага**

1. Дүрс оношилгооны техникч, дүрс оношилгооны эмчийн мэргэжил олгох курст суралцсан үнэмлэх гэрчилгээ бүхий хүнийг рентген аппарат дээр ажиллуулна.
2. Цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын тунгийн хувийн хяналтанд хамруулах, цацрагийн тунг хэмжих хувийн дозиметр, хувийн хамгаалалтын хэрэгслээр хангана. (хормогч, бээлий, нүдний шил, хүзүүвч, малгай, хормой)
3. Эрүүл мэндийн хувьд цацрагтай ажиллахад харшлах өвчингүй эрүүл хүнийг ажиллуулна. Цацрагтай ажиллагчийг хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төвд жилд 1 удаа үзлэгт хамруулж, томилолт, унааны болон эмчилгээний зардлыг байгууллага хариуцна.
4. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамрагдах ажилтны хөнгөлөлтүүдийг олгох, Үүнд: Ажлын нөхцлийн нэмэгдэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн, ажлын цагийн хорогдуулсан цаг, амралтын хоногийн нэмэгдэл
5. Цацрагтай ажиллагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна. Цацрагтай ажиллагчдыг 2 жил тутам цацрагийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулна.
6. Цацрагтай ажиллагчдыг ионжуулагч цацрагийн нөлөөлөлгүй амрах өрөөгөөр хангана.

**Зургаа. Цацрагтай орчинд ажиллагч эмнэлгийн ажилтны эрх үүрэг**

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг дүрмийг чанд мөрдөн ажиллана.
2. Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, цацрагийн ослоос хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.
3. Аппарат тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллганы зааварчилгааг мөрдөж ажиллана. Аппарат тоног төхөөрөмжийн ашиглалтын бүртгэл, (техник ашиглалтын паспорт, техник ашиглалтын журнал 2 ыг заавал хөтлөнө)
4. Зураг авалтын бүртгэлийн журналд үйлчлүүлэгчид өгч буй шарлагын тунгийн хэмжээг заавал тэмдэглэнэ.
5. Хувийн дозиметрыг тогтмол зөв зүүж хэрэглэнэ. Хувийн хамгаалалтын хэрэгслүүдийг өөртөө болон үйлчлүүлэгч, тэдний асран хамгаалагч, эмч мэргэжилтнүүдэд хэрэглүүлэх, энэ талаар зааж сургана. (жирэмсэн эмэгтэйчүүд, ялангуяа ургийн байрлаж байгаа хэсгийг найдвартай хамгаална. Хүүхдэд цацрагийн үүсгүүрээр оношилгоо хийхдээ асран хамгаалагчийн зөвшөөрлийн заавал авна)
6. Рентген оношилгооны үед зураг авах өрөөнд өвчтөнөөс өөр хүн байлгахыг хатуу хориглоно. Зайлшгүй орох тохиолдолд хамгаалах хэрэгслийг бүрэн өмсгөж хамгаалсан байна.
7. Цацрагтай ажиллагч нь жилд нэг удаа хөдөлмөрийн нөхцөл мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төвд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, хордлогын эс тоолуулах үзлэг, шинжилгээнд хамрагдана.
8. Цацрагтай ажиллагч нь мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтанд тогтмол хамрагдаж ЦЦАБХХ-р сард 1 удаа тунгийн хэмжилт хийлгэж үнэлгээ гаргуулна.
9. Цацрагтай ажиллагч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага, хөдөлмөрийн хэвийн нөхцлийг хангах асуудлаар байгууллагын захиргаанд шаардлага тавих, ажиллахаас татгалзах эрх эдэлнэ.
10. Цацрагтай ажиллагч нь туршлага шинжилгээний зүйл болж болохгүй ба аль нэг эрхтнээ үндэслэлгүйгээр цацрагийн нөлөөлөлд өртүүлж болохгүй.

## Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дотоод дүрэм 2023 он

11. Шаардлагатай бол цацрагтай ажилладаг жирэмсэн эмэгтэй хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу ажлын нөхцөлөө өөрчлөх эрхтэй бөгөөд энэ нь түүнийг ажлаас халах үндэслэл болохгүй.
12. Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтанд хамрагдаж байгаа цацрагтай ажиллагчийн ажлын нөхцөл нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарна.

### **Долоо. Цацрагийн хяналтын ажилтны хүлээх үүрэг**

1. Байгууллагын цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын дүрэм, цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, цацрагийн ослоос урдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавина.
2. Байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны талаарх асуудлаар мэргэжлийн байгууллагад хандаж туслалцаа, арга зүйн зөвлөгөө авах, холбогдох мэдээлэл гаргуулж аван хамтран ажиллана.
3. Цацрагтай ажиллагчдад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгнө.
4. Цацрагтай ажиллагчийн авсан тунгийн үнэлгээг мэдээлнэ, хадгална, нэгтгэнэ, удирдлагад танилцуулна.
5. Дозиметрийн ашиглалтын байдалд хяналт тавих (дозиметрийн хэмжилтийн давтамж, гэрээг шинэчлэх, гэмтээх буюу үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох байгуулагаад мэдэгдэж солиулах)

### **Найм. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд (цацрагийн нөлөөлөлд) ажиллагчийн хөдөлмөрийн нөхцөл, нэмэгдэл**

1. Ажлын нөхцөл хортой, хэвийн бус
2. Ажлын нөхцлийн цалингийн нэмэгдэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн өдрийн 250 грамм жимсний цэвэр шүүс, витаминжуулсан ундааны аль нэгээр хангагдана.
3. Ажлын цаг: Долоо хоногийн ажлын цаг 30 цаг байна.
4. Өдөрт ажиллах цаг: 6 цаг байна.  
Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралтын хоног дээр дор дурьдсан нэмэгдэл амралтын өдрийг олгоно.
  - 6-10 жилд ажлын 5, түүнээс дээш өдөр
  - 11-15 жилд ажлын 7, түүнээс дээш өдөр
  - 16-20 жилд ажлын 9, түүнээс дээш өдөр
  - 21-25 жилд ажлын 12, түүнээс дээш өдөр
  - 26-31 жилд ажлын 15, түүнээс дээш өдөр
  - 32, түүнээс дээш жилд ажлын 18, түүнээс дээш өдөр
  -

### **Ес. Болзошгүй ослын үед ажиллах аюулгүй ажиллагаа**

1. Болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөний дагуу зааварчилгааг мөрдөж ажиллана